




2005 оноос эрхлэн гаргав.

ЦДҮС ТӨХК-ИЙН ХЭВЛЭЛ
www.transco.mn

ДАМЖУУЛАХ

Сүлжээ



№05 (158) 2023 оны 12 сар



Монголчууд

Дэлгэр уудам эх орны дөрвөн зүг найман зовхист илч гэрлийг бадраах үйлсэд нэгэн үзүүрт сэтгэлээр зүтгэн, хөдөлмөр бүтээл, авьяас чадвараа харамгүй зориулж яваа эрчим хүчний салбарын нийт ажилтан албан хаагчид болон дамжуулах сүлжээний инженер техникийн ажилтнууд, үе үеийн ахмад буурлууддаа айлчлан ирж буй шинэ оны мэндийг өргөн дэвшүүлэе!

Улиран одож буй 2023 онд Эрчим хүчний салбарын 100 жилийн ой тохиож, арван арванд цогцлоосон бүхнээрээ бахархаж, гавьяа үйлсээ алдаршуулах мөчид манай компаниас төрийн дээд одон медалиар 16, эрчим хүчний болон бусад салбарын тэргүүнээр 38 ажилтан тус тус шагнагдаж хөдөлмөр зүтгэлээ төр түмэндээ үнэлүүлсэн билээ.

Мөдхөн 60 жилийнхээ ойг дархлах “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн хамт олон хичээл зүтгэл, амжилт ололт дүүрэн энэ оныг үдэж байна. Түүхийн нэгэн хуудас дор илч гэрлийн салбарын намтарт гавьяат үйлсийн мөрөө үлдээж, 2023 онд хийж бүтээсэн томоохон ажлуудаас дурдвал;

- “Сонгино” батерей хуримтлуурын станцыг эрчим хүчний нэгдсэн системд залгаж зүгшрүүлэлт хийсэн. Уг батерей хуримтлуурыг ажиллагаанд залгаснаар өвлийн оргил ачааллын цагуудад оргил ачааллыг хааж оролцох шилжүүлэх, импортын эрчим хүчний хэмжээ буурах боломжтой болсон.
- Хяналт, удирдлагын мэдээллийн SCADA системд, “Улаанбаатар” салбарын шилэн кабельд холбогдсон 28 дэд станцыг хамарсан сүлжээ үүсгэсэн. “POWER SCADA” системд Төвийн бүсийн салбарын 110/6 кВ-ын “Давхар”, “Бурхант”, “Үйлдвэр” дэд станцуудын РХА-ийн төлөв байдлыг оруулан алсаас удирдах боломж бүрдсэн.
- Багануур дэд станцын 220 кВ-ын ИХБ-ийн өргөтгөл, РХА-ийн шинэчлэлт, 220 кВ-ын Бөөрөлжүүтийн цахилгаан станцын 220 кВ-ын ЦДАШ-ын барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэсэн.
- Монгол Улсын “Оюутолгой” төсөлд зориулж, “Өвөр- Монголын Эрчим хүчний Олон Улсын Хамтын ажиллагааны компани”-тай “Цахилгаан эрчим хүч худалдан авах, худалдах тухай гэрээ”-ний хүчин төгөлдөр үйлчлэх хугацааг сунгаж, “Нэмэлт гэрээ”-г 2023.05.12-ны өдөр байгуулсан.
- 110 кВ-ын Ерөө-Бугант ЦДАШ-ын тасралтын судалгаа, тооцоонд үндэслэн ОХУ-ын “Полимер аппарат” компанийн үйлдвэрлэсэн хэт хүчдэл хязгаарлагчийг нийт 35тулгуурт суурилуулав.

- Байгалийн гамшигт үзэгдэл, огцом хүйтрэлт, хүчтэй салхи, аадар борооны нөлөөллөөс 220 кВ-ын 203, 204 дүгээр ЦДАШ-ын тулгуур № 68, 220 кВ-ын 215, 216-р ЦДАШ-ын тулгуур №32, 110 кВ-ын Хархорин-А,Б ЦДАШ-ын №463-аас 486-р тулгуурууд мөн № 679-өөс 683-р тулгуурууд хугарсан аваарыг богино хугацаанд арилгаж, хурдан шуурхай гэмтлийг засварлан найдвартай ажиллагааг хангасан.
- 220/110/35 кВ-ын Чойр дэд станцаас буусан автотрансформаторт бүрэн задаргаат их засварын ажил, 110/10 кВ-ын “Буянт-Ухаа” дэд станцын Т-2 трансформаторын гэмтлийг засварлахаа ажлыг хийж гүйцэтгэн, “Эрдэнэт” дэд станцад 63 МВА-ийн Т-1, Т-2 трансформатор, Баянхонгор дэд станцад 16 МВА-ийн Т-1 трансформатор, Мөрөн дэд станцад 6,3 МВА-ийн Т-3 трансформатор, Хархорин дэд станцад 15 МВА-ын, Баянхонгор дэд станцад 5 МВА-ын СВГ суурилуулж ажилд залгалаа.
- Ажилтны үндсэн цалинг тодорхой хувь хэмжээгээр үе шаттай нэмэгдүүлсэн.
- Компанийн алсын хараа, хэтийн зорилгыг хэрэгжүүлэхэд шугам тоноглолын өнөөгийн төлөв байдал, тэдгээрийн ашиглалтад тулгамдаж буй асуудлын талаар харилцан санал солилцож, цаашдын чиг хандлагыг онол, судалгаа, шинжилгээ, хэрэгжүүлсэн туршлага дээр үндэслэн тодорхойлох, шийдвэрлэх зорилгоор “Инженер техникийн ажилтнуудын зөвлөгөөн -2023”-ыг зохион байгууллаа.
- 220 кВ-ын Мандалговь-Арвайхээр, Багануур-Чойр цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, 110/10 кВ-ын “Парк” дэд станцын техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах ажлыг хийж гүйцэтгэв.
- TORKLE – 930 маркийн багажаар 50 дэд станцын аккумуляторын байгууламжид хэмжилт хийж шаардлага хангахгүй болсон шулуутгагч болон аккумуляторын батерейг тодорхойлсон. Мөн OMICRON CPC-100 маркийн багажаар 220, 110 кВ –ын ЦДАШ-ын бодит эсэргүүцлийг хэмжиж микропроцессорын реле хамгаалалт болон аваарын бичигч төхөөрөмжид шугамын параметрийн бодит утгыг оруулсан.

Айлчлан ирж буй шинэ ондоо ололт амжилт бүхнээ бататган ахиулж, чин халуун сэтгэлээр ажил хөдөлмөртөө үнэнчээр зүтгэж, үлгэрлэн дагуулж, эх орны хөгжил дэвшлийн тулгуур болсон Эрчим хүчний салбартаа манлайлагч байгууллага болохын билэгтэй ерөөлийг өргөө!

ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ
ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.ДАШДАВАА

НҮҮР-3

КОМПАНИЙН 2023
ОНЫ ХӨДӨЛМӨРИЙН
АВАРГА, ТЭРГҮҮНИЙ
АЖИЛТАН ТОДОРЛОО

НҮҮР-5

УЛААНБААТАР
САЛБАР

НҮҮР-7


ХАНГАЙН БҮСИЙН
САЛБАР

НҮҮР-9

ГОВИЙН БҮСИЙН
САЛБАР

НҮҮР-11

ЦДҮС ТӨХК-ИЙН
2023 ОНД ХИЙЖ
ГҮЙЦЭТГЭСЭН ШИЛДЭГ
10 АЖИЛ



ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН 2023 ОНЫ “ШИЛДЭГ ИНЖЕНЕР” ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ ТӨХК-ИАС ТОДОРЛОО



Монгол улсын гал голомт болсон эрчим хүчний салбар 2023 онд хийсэн ажлаа дүгнэн шилдэг байгууллага, бүтээн байгуулалт, менежер, ерөнхий инженер, инженер, мастер, ажилтнаа тодруулж, шагналыг гардуулав. Оны шилдгүүдэд Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, дэд сайд М.Баярмагнай, Эрчим хүчний яамны төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх нар шагналыг гардуулж, баяр хүргэлээ. Шагнал гардуулах ёслолын арга хэмжээ 2023 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Эрчим хүчний яамны хүндэтгэлийн

танхимд болсон бөгөөд Эрчим хүчний салбарын оны “Шилдэг инженер”-ээр ЦДҮС ТӨХК-ийн Засвар зохицуулалт, төслийн хэлтсийн ахлах бөгөөд шугамын засварын инженер С.Ариунбат шалгарч, Эрчим хүчний сайдын нэрэмжит шагналыг Шуурхай зохицуулалтын хэлтсийн дарга Ж.Чинзаяа хүртлээ. Компанийнхаа нэрийг өндөрт өргөн хамт олноо манлайлж, энэхүү нэр хүндтэй шагналын эзэн болсон С.Ариунбат, Ж.Чинзаяа нартаа баяр хүргэж, ажил хөдөлмөрийн өндөр амжилтыг хүсэн ерөөе!



ТЕСЛА БА ЭДИСОН УРАЛДААНЫ ДҮН ГАРЛАА



Тесла ба Эдисон уралдааны шилдэг төсөл төрөлд тэргүүн байр эзэлсэн
УБС-ын Шугамын засварын монтёр
Р.МӨНГӨНСАРУУЛ



Тесла ба Эдисон уралдааны шилдэг төсөл төрөлд дэд байр эзэлсэн
ХБС-ын мэдээлэл технологи, компьютерийн инженер
Э.БАТНЯМ

Ажилтнуудын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, оновчтой санал, бүтээлийг дэмжиж урамшуулах “Тесла ба Эдисон” уралдааны “Шилдэг төсөл” төрөлд тэргүүн байрыг Улаанбаатар салбарын шугамын засварын монтёр-гагнуурчин Р.Мөнгөнсаруул “Гурван фазын утсыг тулгуурт нэгэн зэрэг өлгөх, буулгах шинэ санаа” төслөөр, дэд байрыг Хангайн бүсийн салбарын мэдээлэл технологи, компьютерийн инженер Э.Батням “Цахилгаан дамжуулах агаарын шугамын үзлэгт зориулан УАЗ-450 машиныг камераар тоноглох” төслөөр тус тус эзлэв. “Шилдэг бүтээл” төрөлд “Компанийн хэмжээнд Дата менежмент буюу мэдээ, мэдээллийн нэгдсэн хяналтын самбар нэвтрүүлэх” (Dashboard) бүтээлээр Мэдээллийн технологийн хэлтсийн Ц.Баянмөнх удирдагчтай, компьютерийн ашиглалтын инженер Ш.Аюурзана, программын ашиглалтын инженер Б.Болормаа, программист инженер Б.Баярмаа нарын бүрэлдэхүүнтэй баг тэргүүн байрыг эзэлсэн бол Төвийн бүсийн салбарын мэдээлэл технологи компьютерийн инженер Э.Амарсанаа, зураг төсөл, мэдээллийн хяналтын инженер Э.Ариунбилэг, компьютер техник хангамжийн инженер Д.Золзаяа тэргүүтэй баг “Сургалтын шалгалтын онлайн систем” бүтээлээр удааллаа. “Тесла ба Эдисон” уралдааны шилдгүүддээ баяр хүргэж, ажлын амжилт хүсье!



Тесла ба Эдисон уралдааны шилдэг бүтээл төрөлд тэргүүн байр эзэлсэн баг хамт олон



Тесла ба Эдисон уралдааны шилдэг бүтээл төрөлд дэд байр эзэлсэн ХБС-ын баг, хамт олон

КОМПАНИЙН 2023 ОНЫ ХӨДӨЛМӨРИЙН АВАРГА, ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН ТОДОРЛОО

Компанийн жилийн эцсийн тайлангийн хурал 12 дугаар сарын 21-ний өдөр боллоо. Тус хурлаар компанийн “Шилдэг 10 ажил”-аа танилцуулж, хөдөлмөрийн аварга, тэргүүний ажилчдаа шалгарууллаа. “Хөдөлмөрийн аварга-Инженер техникийн ажилтан”-аар Зүүн-Өмнөд бүсийн салбарын Реле хамгаалалт,автоматик, хэмжилт туршилтын албаны ахлах бөгөөд нийлмэл реле хамгаалалт,автоматикийн инженер Б.Мягмарсүрэн, “Хөдөлмөрийн аварга-Шуурхай ажиллагааны инженер техникийн ажилтан”-аар

Улаанбаатар салбарын Ашиглалт, шуурхай үйлчилгээний албаны ахлах бөгөөд диспетчер инженер З.Наранзул, “Хөдөлмөрийн аварга-Ашиглалтын монтёр”-оор Хангайн бүсийн салбарын ашиглалт шуурхай үйлчилгээний албаны 110/35/10 кВ-ын Арвайхээр дэд станцын ээлжийн монтёр Ж.Идэрзаяа, “Хөдөлмөрийн аварга-Засварын монтёр”-оор Төв удирдлагын Засвар зохицуулалт, төслийн хэлтсийн засварын монтёр Б.Мэнд-Амар, “Хөдөлмөрийн аварга-Албан хаагч”-аар Улаанбаатар салбарын Захиргаа аж ахуйн албаны ахдлах бөгөөд дотоод ажил хариуцсан

мэргэжилтэн Т.Аюуш, “Хөдөлмөрийн аварга-ажилтан”-аар Төвийн бүсийн салбарын Тээвэр механизмын хэсгийн тусгай зориулалтын машин, механизмын жолооч Х.Ганбаатар, “Хөдөлмөрийн аварга-Удирдах албан тушаалтан”-аар Говийн бүсийн салбарын ерөнхий инженер Д.Цэрэндамба, Төв удирдлагын “Тэргүүний ажилтан”-аар Тээвэр механизмын хэлтсийн суудлын автомашины жолооч Ц.Батбаатар нар тус тус шалгарав. 2023 оны хөдөлмөрийн аварга, тэргүүний ажилтан, албан хаагчиддаа баяр хүргэж, ажлын амжилт хүсье!



Хөдөлмөрийн аварга-Инженер
техникийн ажилтан
Б.МЯГМАРСҮРЭН



Хөдөлмөрийн аварга-Шуурхай
ажиллагааны ИТА
З.НАРАНЗУЛ



Хөдөлмөрийн
аварга-Ашиглалтын монтёр
Ж.ИДЭРЗАЯА



Хөдөлмөрийн аварга-Засварын монтёр
Б.МЭНД-АМАР



Хөдөлмөрийн аварга-Албан хаагч
Т.АЮУШ



Хөдөлмөрийн аварга-Ажилтан
Х.ГАНБААТАР



Хөдөлмөрийн аварга-Удирдах
албан тушаалтан
Ц.ЦЭРЭНДАМБА



Төв удирдлагын тэргүүний ажилтан
Ц.БАТБААТАР

ОНЫ ШИЛДЭГ ДЭД СТАНЦААР ЗҮҮН-ӨМНӨД БҮСИЙН САЛБАРЫН “БОР-ӨНДӨР” ДЭД СТАНЦ ШАЛГАРАВ

“Ажлын байрны соёл-5С” хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсэн 2023 оны “Шилдэг дэд станц” номинацийн тэргүүн байрыг Зүүн-Өмнөд бүсийн салбарын “Бор-Өндөр” дэд станц эзэллээ. Дэд байрт Хангайн бүсийн салбарын “Баянхонгор” дэд станц шалгарсан бол Улаанбаатар салбарын “Баянчандмань” дэд станц удаалав. Шилдэг дэд станц номинацид шагналт байранд шалгарсан хамт олонд баяр хүргэж,ажлын амжилт хүсье!



“Бор-Өндөр” дэд станцын хамт олон



“Баянхонгор” дэд станцын хамт олон




“Баянчандмань”
дэд станцын
хамт олон

ЦДҮС ТӨХК-ИЙН ҮЙЛДВЭРЧИНИЙ ХОРОО ОНЫ ШИЛДГЭЭР ШАЛГАРЛАА



Монголын эрчим хүч, геологи уул уурхайн үйлдвэрчний эвлэлийн холбоо 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдөр оны шилдгүүдээ шалгаруулж, шагналыг гардууллаа. “Шилдэг хороо”-гоор ЦДҮС ТӨХК-ийн үйлдвэрчний хороо тодорсон бол “Шилдэг менежер”-ээр ЗӨБС-ын Үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга Б.Чинбат шалгарч, шагналаа гардаж авсан юм. МЭХГУУ-н Үйлдвэрчний холбооны оны шилдгээр шалгарсан та бүхэнд компанийн хамт олны нэрийн өмнөөс баяр хүргэж, ажлын амжилт хүсье!



ТӨВ УДИРДЛАГА

"ТОГ-ОО ТОХИРУУЛ" 17:00-22:00 ЦАГ

НӨЛӨӨЛЛИЙН АЯН ЭХЭЛЛЭЭ



Олон нийтэд эрчим хүчний хэмнэлттэй, үр ашигтай, хэрэглээг хэвшүүлэх "Тог-оо тохируул" 17:00-22:00 цаг нийгмийн нөлөөллийн аяныг эхлүүлж байна. Аяны нээлт 11 дүгээр сарын 28-ны өдөр Дулааны 3-р цахилгаан станцад боллоо. Нээлтийн үйл ажиллагаанд Эрчим хүчний дэд сайд М. Баярмагнай, Эрчим хүчний зохицуулах хорооны дарга Э. Түвшинчулуун, тус аяныг Монголын эрчим хүчний засаглал хөтөлбөрийн хүрээнд дэмжин ажиллаж буй АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн Хөгжлийн асуудал хариуцсан дэд дарга Стив Уинкейтс болон салбарын бусад мэргэжилтнүүд, инженер техникийн ажилчид оролцож, мэдээлэл өглөө.

"Тог-оо тохируул" 17:00-22:00 цаг нөлөөллийн аяныг эрчим хүчний салбараас санаачлан хэрэгжүүлж, иргэн, айл өрх, албан байгууллага, аж үйлдвэр зэрэг хэрэглэгч бүрт эрчим хүч хэмнэх арга, зөв дадал, хэмнэлттэй, ухаалаг хэрэглээг төлөвшүүлэх замаар эрчим хүчний өсөн нэмэгдэх хэрэгцээг зохицуулах, эрчим хүчний оргил цагийн ачааллыг бууруулах зорилготой юм.

Өвлийн улиралд манай улсын эрчим хүчний хэрэглээ огцом өсөж, 17-22 цагийн хооронд эрчим хүчний системийн ачаалал эрс нэмэгддэг. Энэ үед чадлын дутагдалд орох, импортын хэрэглээ нэмэгдэх, улмаар эрчим хүчний хязгаарлалт хийх болзошгүй эрсдэлтэй. Тиймээс иргэн, айл өрх, аж ахуй нэгж, эрчим хүчний хэрэглэгч бүр ТОГ-оо тохируулж, хэмнэлттэй хэрэглээнд нэгдсэнээр эдийн засгийн болон байгаль орчны асар их үр өгөөжтэй.

"Тог-оо тохируул" 17:00-22:00 цаг нөлөөллийн аяны хүрээнд хэмнэлт хийх, технологийн шийдэл, эрчим хүч хэмнэх энгийн арга, эрчим хүчний хэмнэлт, үр ашгийн талаар мэдлэг ойлголтыг тогтмол түгээнэ. Иргэн бүр мэдлэг, ойлголттой болсноор эрчим хүчний нийт хэрэглэгчид хэмнэлттэй, ухаалаг хэрэглээний зөв дадалтай болох ач холбогдолтой гэдгийг тус арга хэмжээнд хүрэлцэн ирсэн салбарын удирдлагууд онцолж, тогоо тохируулж, нийтээрээ эрчим хүчээ хэмнэхийг уриалав.

ИНЖЕНЕР ТЕХНИКИЙН АЖИЛТНУУДЫН ЗӨВЛӨГӨӨН БОЛОВ

ЦДҮС ТӨХК-ийн "Инженер техникийн ажилтнуудын зөвлөгөөн-2023" арга хэмжээг 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр амжилттай зохион байгууллаа. Тус зөвлөгөөнд 5 салбар, төв удирдлагаас төлөөлж нийт 95 гаруй инженер техникийн ажилтнууд, урилгаар компанийн ахмадын хорооны дарга, Монгол Улсын зөвлөх инженер Л.Дарамбазар, "Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн" ТӨҮГ-ын Ерөнхий инженер Ш.Энхбаатар, ШУТИС-ын барилга архитектурын сургуулийн

профессор Я.Дүйнхэржав нар оролцсон. Компанийн алсын хараа, хэтийн зорилгыг хэрэгжүүлэхэд шугам тоноглолын өнөөгийн төлөв байдал, тэдгээрийн ашиглалтад тулгамдаж буй асуудлын талаар харилцан санал солилцож, цаашдын чиг хандлагыг онол, судалгаа, шинжилгээ, хэрэгжүүлсэн туршлага дээр үндэслэн тодорхойлох, шийдвэрлэх зорилгоор доорх сэдвүүдээр илтгэл, хэлэлцүүлэг хийж санал солилцсон юм.



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Н.ТАВИНБЭХ ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ ТӨХК-Д АЖИЛЛАЛАА




Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэхээр ахлуулсан ажлын хэсэг "Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" ТӨХК-д 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр ажиллалаа. 2023-2024 оны өвлийн их ачааллын бэлтгэл ажлын явцтай танилцаж, салбарын голлох компанийн хувьд өндөр хариуцлагатай ажиллахыг анхааруулж, аваарын нөөцийн худалдан авалтыг шуурхай зохион байгуулах, цалинг нэмэгдүүлсэнтэй холбоотой ажилчдын сэтгэл ханамжийн судалгаа гаргах, шугам тоноглолд чанартай үзлэг тогтмол хийх, ажилчдын сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэх, аваар осолгүй ажиллахыг үүрэг болгов.

СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАВ

Нийгмийн даатгалын багц хуулийг таниулах сургалт, уулзалтыг танхим болон цахим хэлбэрээр 2023 оны 11 дугаар сарын 16-ны өдрүүдэд зохион байгуулж, тус сургалтад танхимаар 40, цахимаар 50 цэгээс 150 гаруй ажилтан хамрагдсан.



Мэдээллийг бэлтгэсэн: ЗУХ-ийн хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах мэргэжилтэн Д.Энхбаяр



УЛААНБААТАР САЛБАР

ХАБЗА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

Сар бүрийн 2 дахь 7 хоногийн мягмар гаригт зохион байгуулагддаг “Хөдөлмөрийн аюулгүй байдлын өдөр”-ийг 2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр зохион байгуулж, ажилтнууд танхимын болон цахим хэлбэрээр хамрагдсан. Тус өдрөөр ХАБЭА, хяналтын ахлах инженер Н.Нямдаваа “Үзлэг, шалгалт хийх тухай” сэдвээр, ДҮТ ТӨХХК-ийн ХАБЭА, хяналтын инженер Г.Чогдон “Аюулыг мэдээлэх хуудсын хэрэгжилт, эрсдэлийн үнэлгээ” сэдвээр танилцуулга, сургалт явуулж, хуулийн зөвлөх М.Мөнхчимэг шинэчлэн батлагдсан “Цаг ашиглалтын журам”-ын талаар ажилтнуудад мэдээлэл өгсөн.



“Хөдөлмөрийн аюулгүй байдлын өдөр”-ийн үеэр

Хяналт шалгалт

Дэд станцын ажлын байруудад галын дүгнэлт сунгуулах болон нийслэлийн дүүргүүд, Төв аймгийн Онцгой байдлын хэлтсийн гал түймрийн улсын хяналтын байцаагч нар дэд станцуудад галын үзлэг шалгалт хийх ажлыг зохион байгуулж, үзлэг шалгалтын мөрөөр ирүүлсэн албан шаардлагын дагуу ажил зохион байгуулж ажилласан. Мөн Баянзүрх, Налайх дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гал унтраах ангийн захирагчаар Налайх Туул, Зайсан, Дүнжингарав, Хүрхрээ, Дорнод-2, Улаанбаатар, Улаанхуаран, Амгалан,

Дулаан, Умард, Шонхор, Телевиз нийт 13 дэд станцад гал унтраах шуурхай төлөвлөгөөг боловсруулж батлуулсан.



Хамгаалалтын зурвас

Барилга, хот байгуулалтын яамнаас Геодези зураг зүйн улсын ахлах байцаагч Д.Бямбадулам, Барилга байгууламжийн улсын байцаагч Б.Эрхэмбаяр, Геодези зураг зүйн улсын байцаагч А.Даваажав нарын хамт 211,212 дугаар цахилгаан дамжуулах агаарын шугамын тулгуур№16-21-ийн хооронд трассын дагуу дулааны шугам татах ажил хийгдэж байгаатай холбогдуулан хяналт шалгалт хийсэн.

ИХБ-4-ийн урд 220, 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын хамгаалалтын

зурваст том оврын автомашин механизм оруулж тавьдаг, өргөх зөөх машин механизмаар ажил гүйцэтгэдэг зөрчил удаа дараа гардаг тул түүнээс сэргийлж хамгаалалтын зурвасыг хашсан хаалт, хашааг сэргээж засварласан.

105,106 дугаар цахилгаан дамжуулах агаарын шугамын тулгуур№19-20-ын хооронд хамгаалалтын зурваст хашаа барьж байсан зөрчлийг арилгуулах арга хэмжээ авсан.



Ээлжит болон ээлжит бус сургалтууд

Сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу Сингапур улсад 2023.11.06-10-ны өдрүүдэд зохион байгуулсан “Микропроцессорын РХА-ийн нарын дотоод функц” сургалтад Реле хамгаалалт автоматик, хэмжилт, туршилтын албаны нийлмэл реле хамгаалалтын инженер Б.Тогтохжаргал хамрагдсан.

Япон улсад 2023.11.12-24-ний өдрүүдэд зохион байгуулагдсан SWG-1,3 багуудын /Горим, RTDS/ сургалтад Инженерийн албаны дарга М.Ганзориг, горим тооцооны инженер Б.Золбаяр, баланс тооцоо, хэмнэлтийн инженер А.Маралмаа нар хамрагдсан.



Ашиглалт, шуурхай үйлчилгээний албаны дэд станцын ашиглалтын инженер Ч.Баяраа, О.Золбуян нарыг 2023.11.15-17-ны өдрүүдэд ЭХҮТ-ийн СҮТ-өөс зохион байгуулсан Мастерийн сургалтад хамруулсан.



Төвийн бүсийн салбарын сургалтын баазад 2023.12.11-15-ны өдрүүдэд зохион байгуулсан АШҮА-ны ажилтнуудыг РХА-ийн чиглэлээр чадавхжуулах сургалтад Ашиглалт, шуурхай үйлчилгээний албаны дэд станцын ашиглалтын инженер Т.Ганзориг, дичпетчер инженер Б.Дэлгэрцогт нарыг хамруулсан.



АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

“Сонгино” Батарей хуримтлуурын станцыг сүлжээнд залгах

“Эрчим хүчний сүлжээнд ашиглах том чадлын хуримтлуур”-ын төслийн хүрээнд “80 МВт-ын чадалтай, 200 МВт цагийн багтаамжтай эрчим хүчний хуримтлуурын байгууламж”-ийн барилга угсралтын ажил дууссантай холбогдуулан Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 11-р сарын 10-ны өдрийн тушаалын дагуу техникийн комисс барилга угсралтын ажил болон батарей хуримтлуурын ажлын онцлогтой уялдуулан шат дараалалтай ажилласан. Үүнд:

- Батарей хуримтлуурын станцын 110 кВ-ын тоноглолууд болох Сонгино дэд станц дахь 110 кВ-ын өргөтгөлийн тоноглолуудыг хүчдэлд залгах ажлын хүрээнд Сонгино дэд станцад 110 кВ-ын 1,2-р систем шин, тойруу систем шинийг бүрэн чөлөөлсөн. Улаанбаатар дэд станц болон ИХБ-4-т бүх ачааллыг шилжүүлж схемийн зохицуулалт хийж, нийт 363 үйлдэл бүхий сэлгэн залгалтыг амжилттай гүйцэтгэн буцааж хэвийн горимд оруулсан.
- Сонгино батарей хуримтлуурын станцын 100 МВА чадал бүхий 110/35 кВ-ын хүчний трансформатор, ДХТ-1,2,3,4 трансформаторуудыг туршилтын

хүчдэлд залгасан. Мөн 2023 оны 12-р сарын 6-ны өдрийн 17:42 цагаас 12-р сарын 7-ны өдрийн 03:25 цаг хүртэл 595 үйлдэл бүхий сэлгэн залгалтын батлагдсан программын дагуу 3500 кВА чадал бүхий 35000/690 В-ын хүчдэлтэй PCS-н трансформаторуудыг туршилтын хүчдэлд амжилттай залгасан.



Их засварын ажлаар 110/10 кВ-ын Баруун дэд станцын 10 кВ-ын РП-21А таслуур вакуум алдагдаж, шинээр АBB VS-1 маркийн таслуурыг солихоор хэмжилт туршилт хийлгэж, таслуурын үүрэнд хийж, раземийг холбож, хяналтын байрлалд удирдлагаар тасалж залган шалгаж хүлээлгэн өгсөн.



Гэрээт ажлаар ЦДҮС ТӨХК болон Улаанбаатар электро монтаж ХХК хоорондох гэрээний дагуу 107-р АШ-ын тулгуур№18-д 3 фазын шлейф тайлах, хуучин ПБ110-4 маркийн завсрын тулгуур №13-н 3 фазын утсыг тулгуурын хамт буулгаж, шинээр У110-2+9 маркийн анкер тулгуур босгож, хөндлөн траверст утсыг бэхлэх, 107,108-р АШ-ын тулгуур№13,14-н ПБ-110-4 маркийн завсрын тулгууруудыг У-110-2+9 маркийн 2ш анкер тулгуураар сольж, OPGW-Ж11 маркийн аянгын тросс болон АСМСС-295/40 маркийн дамжуулагч утас шилжүүлж бэхэлгээ хийх, шинээр босгосон У110-2+9 маркийн тулгуур №13,14-н 2 ширхэг анкер тулгуур суурилуулсны дараа 107-р АШ-ын тулгуур №18-д 3 фазын шлейф уях, газардуулга гагнаж, суурийн ивээс хийх ажлыг тус тус гүйцэтгэсэн.

Мэдээллийг бэлтгэсэн: УБС-ын ЗААА-ны ахлах бөгөөд дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Т.Аюуш




№13 анкер тулгуурын хөл тавих тулгуур угсралтын ажил



№14 анкер тулгуур угсрах ажлаар



№13, 14 ПБ110-4 тулгуур буулгах ажлаар



№13, 14 анкер тулгуур босголтын ажил



ХАНГАЙН БҮСИЙН САЛБАР

ХАБЭА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

Салбарын хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр 11, 12 дугаар саруудад дараах ажлууд хийгдсэн.

Ээлжит шалгалт: Салбарын хэмжээнд шинээр ажилд орсон болон ажлын байр өөрчлөгдсөн ажилтнуудаас дагалдан суралцах программын дагуу шалгалтын комисс тухай бүр шалгалт авч 1 ажилтныг жинхлүүлэн, 1 ажилтанд шинээр групп олгон, 13 ажилтны группыг ахиулсан байна.

Наряд, шийдвэрээр хийгдсэн ажил: Салбарын харъяа нийт 12 дэд станцын тоног төхөөрөмжүүд болон 110кВ, 220кВ-ын ЦДАШ-уудад нарыдаар 58, шийдвэрээр 175 удаагийн ажил гүйцэтгэж, зөрчил дутагдалгүй ажиллалаа.

Ажил гүйцэтгэх бригадуудын нийт 582 ажилтанд тухайлсан зааварчилгааг өгч ажилласан байна.


Дасгал, зааварчилгааны талаар: Шинээр ажилд орсон 3 ажилтанд урьдчилсан зааварчилгаа, 10 ажилтанд ажлын байрны анхан шатны зааварчилгаа, 2140 ажилтанд өдөр тутмын зааварчилгаа, 130 ажилтанд сар бүрийн ээлжит зааварчилгаа, ээлжит бус зааварчилгааг 235 ажилтанд тус тус өгч ажилласан байна.

Салбарын алба, хэсэг, дэд станцууд дээр аваар эсэргүүцэх дасгал 3 удаа хийгдэж нийт 35 ажилтан, гал эсэргүүцэх дасгал 5 удаа хийгдэж нийт 64 ажилтан, осол эсэргүүцэх

дасгал 5 удаа хийгдэж нийт 59 ажилтан тус тус хамрагдсан байна.

ХАБЭА-н бүх шатны үзлэг: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн анхан шатны үзлэгийг давхардсан тоогоор 71 удаа хийж 119 зөрчил, II шатны үзлэгийг 13 удаа хийж 41 нэрийн зөрчил, III шатны үзлэгийг 9 удаа хийж 52 зөрчилийг илрүүлэн нийтдээ 212 зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээг авч ажиллалаа.

2023 оны 12-р сарын 04-өөс 08-ны өдрүүдэд Хишиг-Өндөр, Сансар, Хархорин, Цэцэрлэг, Арвайхээр, Баянтээг, Баянхонгор дэд станцуудад ХАБЭА-н III шатны үзлэг шалгалт хийж, илэрсэн зөрчлүүдийг устгах хугацаатай даалгавар өглөө.



Салбарын хэмжээнд 2-р зэргийн саатал 2 бүртгэгдсэн. Үүнд:

2023.12.10-ны өдөр 110 кВ-ын Тэлмэн ЦДАШ-ын тулгуур №559-н I фазын утасны №560 талын чичиргээ намжаагчийн угаар утас чангарч, гадна үеийн судал тасарч халалт үүснээс тасарч унасан. Тасралтын улмаас нийт 31263,13 кВт.цаг цахилгаан

эрчим хүч дутуу түгээж, 2 аймгийн 40 сумын 24693 айл өрх, 3564 аж ахуйн нэгжүүд цахилгаан эрчим хүчээр хязгаарлагдсан байна.

2023.12.16-ны өдөр Хархорин дэд станцын Т-2 трансформаторын тэлэгч банкаас хийн релерүү холбогдсон хоолойд тос царцаж, бөглөрснөөс тосны түвшин буурч хийн хамгаалалт ажиллаж, тасралт гарсан. Тасралтын улмаас нийт 13921.75 кВт.цаг цахилгаан эрчим хүч дутуу түгээж, 3 аймгийн 16 сумуудын 12657 хэрэглэгч, 1717 аж ахуйн нэгжүүд цахилгаан эрчим хүчээр хязгаарлагдсан.

Бусад ажлын талаар:

11-р сарын 07-10-ны өдрүүдэд салбарын харъяа Баянхонгор, Арвайхээр, Хархорин, Хишиг-Өндөр, Булган, Эрдэнэт дэд станцуудад 2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг шалгахад компанийн ТБХ-ийн ахлах бөгөөд ашиглалтын инженер Б.Энхбатаар ахлуулсан комисс ажиллаж, илэрсэн зөрчлүүдийг арилгах үүрэг даалгавар өгсөн.



11-р сарын 12-оос 24-ны өдрүүдэд Япон улсын Жайка олон улсын хамтын нийгэмлэгээс зохион байгуулсан "Сэргээгдэх эрчим хүчний оролцоо ихтэй ЭХС-ийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэх" сэдэвт сургалтанд ХАБЭА-н инженер М.Бат-Эрдэнэ, РХАХТА-ны дарга М.Энхтайван нар хамрагдсан.



2023 оны 11 дүгээр сарын 9, 10-ны өдрүүдэд Орхон аймагт Эрчим хүчний салбарын хяналтын ажилтны зөвлөгөөн болов. Уг зөвлөгөөнд салбарын 38 ААН, байгууллагын хяналт, аудитын 150 гаруй ажилтнууд оролцож, байгууллагуудын хууль тогтоомж, дүрэм журмын биелэлтийг хангуулах, үйл ажиллагаанд гарч буй зөрчил дутагдал, осол аваар, сааталд үнэлэлт өгөх, зөвлөмжөөр хангах, хариуцлага тооцож ажиллах чиг үүргийг хэрэгжүүлэхэд тус салбарын хяналтын ажилтнуудад тулгамдаж буй асуудал, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангах, технологийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зэрэг харилцан туршлага солилцлоо. Зөвлөгөөнд ХМХ-ийн дарга Д.Мөнхзаяа, ТБС-ын ХАБЭА-н инженер Наранбаатар, ХБС-ын ХАБЭА-н инженер Ж.Анхбаяр нар оролцлоо.


АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

Засварын ажлын явц:

- Их засварын тодотгосон төлөвлөгөөний дагуу нийт гүйцэтгэл 74 нэр төрлийн ажлаас 74 ажил хийгдсэн 100 хувийн биелэлтэй.
- Урсгал засвараар 84 нэр төрлийн ажлаас 81 нэр төрлийн ажил хийгдсэнээр 96,42 хувийн биелэлттэй.
- ТЗБАХ-ний тодотгосон төлөвлөгөөний дагуу 14 нэр төрлийн ажлаас 14 ажил хийгдэж 100 хувийн биелэлттэйгээр тус тус гүйцэтгэсэн.

Урсгал засвараар хийгдсэн ажлууд:

- Эрдэнэт дэд станц 35кВ-ын I секцийн ХС-уудын УЗА



- Эрдэнэт дэд станц ОПУ, ИХБ-н гэрэлтүүлгийн УЗА




- Эрдэнэт дэд станц ЗРУ 6кВ-н ХХБ-д УЗА тус тус хийгдсэн.

Гэмтэл устгалтаар хийгдсэн ажлууд


- 110 кВ Баянхонгор ЦДАШ-ын тулгуур №757,759 хазгай тулгуур тэгшлэх



- Хишиг-Өндөр дэд станц Т-1 10кВ-н оролтын РХАБ-д гэмтэл устгах, гэмтэл тодорхойлох /Т-1 35/10кВ-ын КЛ-3 реле таслах ороомог сольсон. Од, КЗ-ын гацалтыг гаргасан./



- Хишиг-Өндөр дэд станц 110кВ-н ОД, КЗ-ын приводны халаагуурын кабель солих



- Хялганат 110кВ-н Т-2 тр-н термометрийн труппий гэмтэл устгах



- Эрдэнэт дэд станц 35кВ-н Р-2-н тосон таслуурын С фазын тос гоожсон гэмтэл устгах /35кВ-н Р-2 дээр редуктор дагаж тос гоожсон байсанг арчиж цэвэрлэн чангалгаа хийсэн/


- Эрдэнэт дэд станц 35кВ-н СХТ-н хяналтын кабель солих



- Эрдэнэт дэд станц 35кВ-н Блок-1 АШ-н У-12 панельд таслуурын залгаатай төлөв заагч гэрэл шатсаныг солих
- Эрдэнэт дэд станц ТГЦ-ний гэмтэл устгах



- Баянтээг 35 кВ-ын Баруунбаян-Улааны гаргалгын гэмтсэн халаагуур солих
- Арвайхээр ОПУ-н халаагуурын удирдлагын пускатель солих
- Хялганат 110 кВ-н ВМТ халаагуурын автомат солих
- Хархорин 15 МВар-н СВГ-д 10 кВ кабелийн муфт хийх




- Тэлмэн АШ ТН559-560 хооронд утас тасарсан гэмтэл устгах



Салбарын хэмжээнд шугам, тоноглолын найдвартай ажиллагааг хангах зорилгоор дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Булган дэд станц Хутаг-1 АШ-н гүйдлийн трансформатор коэффициентийг солих
- Хархорин дэд станц ШинТойт-ын халаагуурын кабель зэсварлах
- Хархорин дэд станц кабелийн тоннелийн цэвэрлэгээ хийх, нүх сүвийг битүүлэх
- Хархорин дэд станц 10кВ-н ХХБ-н хаалганы дулаалга хийх
- Цэцэрлэг дэд станц кабелийн түннэл дулаалах хог шороог цэвэрлэх
- Тосны сорьц авах
- Эрдэнэт дэд станц 110 кВ-ын ГОК-Г, Д АШ-н ГТ-н алдаа шалгах
- 110кВ-н Мөрөн АШ-н анкерийн шлейфний халалт хэмжих
- Арвайхээр дэд станц ОПУ-ийн кабелийн туннель цэвэрлэх
- Булган дэд станц 110 кВ-н Булган-А АШ-н таслуурт хэмжилт хийх

Мэдээллийг бэлтгэсэн: ХБС-ын ЗААА-ны сургалт, бүтээмжийн инженер Б.Ундрах





ЗҮҮН-ӨМНӨД БҮСИЙН САЛБАР

ХАБЭА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

Салбарын алба, хэсэг, дэд станцуудад сар бүр батлагдсан төлөвлөгөөний дагуу хийгдэж байгаа бүх төрлийн дасгалын явц, түүний чанарт тогтмол хяналт тавьж ажиллаж байна.

2023 оны эхнээс урьдчилсан зааварчилгаанд 31 ажилтан, сарын давтан зааварчилгаанд 1723 ажилтан, ээлжит бус зааварчилгаанд 1717 ажилтан, өдөр тутмын давтан зааварчилгаанд 21017 ажилтан давхардсан тоогоор тус тус хамрагдаад байна.

2023 оны 4-р улирлын ХАБЭА-н болон ашиглалт засварын 3-р шатны үзлэг шалгалтыг зохион байгуулж, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн 7 үзүүлэлт, аюулгүй ажиллагаа, галын аюулгүй байдлыг хангах 5 үзүүлэлт нийт 12 үзүүлэлт тус бүрээр Өндөрхаан, Бор-Өндөр, Баянмөнх, Чойр, Айраг, Сайншанд, Ширээт, Замын-Үүд, Борхойн, Багануур, Хот, Төв дэд станцууд, Реле хамгаалалт автоматик хэмжилт туршилтын алба, Засварын алба, Ашиглалт шуурхай үйлчилгээний алба, Захиргаа аж ахуйн албанд хяналт шалгалт хийгдэж, салбарын хэмжээнд 194 зөрчил, дэд станцууд болон хэсэг, албадуудад ашиглалт засварын 7 үзүүлэлтээр 2023 оны II улиралд хийгдсэн засварын ажлын гүйцэтгэл, ашиглалтын паспортын баяжилт, хөтлөлт, схем зааврын бүрдэлт, мөрдөгдөж байгаа байдал, тоноглолын үзлэг графикийн



дагуу хийгдэж байгаа эсэх, өмнөх үзлэгээр илэрсэн зөрчлийг устгасан байдал зэрэгт үзлэг шалгалт хийхэд 109 зөрчил, дутагдал тус тус илэрч, зөрчлийг арилгах үүрэг даалгавар өгөгдсөн байна.



2023 оны 11-р сарын 25-ны өдөр салбарын хэмжээнд аваарийн цуглалалт зохион байгуулж, ажилтнуудын болон машин механизмын бэлэн байдлыг шалгаж,

илтгэх хуудсаар салбарын удирдлагуудад танилцуулж ажилласан. Салбарын хэмжээнд 216 ажилтан ажиллахаас 190 ажилтан ажиллаж байгаа бөгөөд тухайн үед ээлжинд 24 ажилтан, ээлжийн амралттай 6 ажилтан, өвчтэй 6 ажилтан, салбарын даргаас чөлөө авсан 8 ажилтан, алба, хэсгийн дарга, АШҮ-ний инженер нь чөлөө өгсөн 15 ажилтан байсан. Аваарын цуглалалтаар ирэх ёстой 126 ажилтнаас 118 ажилтан ирж, ирц салбарын хэмжээнд 93,7 %-тай байлаа. Багануур хэсгийн ажилтнуудын ирц 87,7 %, харьяа дэд станцуудын ажилтнуудын ирц 100,0 %-тай байлаа.

Компанийн ерөнхий инженерийн 01/2023 тоот албан даалгаврын хүрээнд салбарын хэмжээнд хийгдсэн ажлын тайланг гаргаж, ХМХ-т хүргүүлсэн.

ХАБЭА-н ISO 45001:2018 стандартыг төв удирдлага, Улаанбаатар салбарт нэвтрүүлэн ажиллахтай холбоотойгоор OBSERVE CONSULTING компанийн танилцуулга, цахим сургалтад оролцсон.

Салбарын ажлын байрны сургалтын хүрээнд нийт ажилтнуудын сургалтыг 2023 оны 12-р сарын 21,22-ны өдрүүдэд "Ошима" сургалтын төвтэй хамтран зохион байгуулсан.

АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

Засварын ажлын талаар:

2023 оны Их засвар, ТЗБАХ-ний ажлын гүйцэтгэл

2023 онд тодотгосон төлөвлөгөөгөөр ТЗБАХ-ний 20 ажлыг 3.6 тэрбум төгрөгийн зардалтайгаар хийж гүйцэтгэхээс 13 нэр төрлийн ажлыг 439.1 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн бол 220/110/35 кВ Багануур дэд станцын өргөтгөлийн ажлын явцын гүйцэтгэл 840.5 сая төгрөгөөр хийгдсэн байна. Дараах ажлууд гүйцэтгэх шатандаа явж байна.

Багануур дэд станцад 220 кВ АТ-1,2 Гүйдлийн тр, 220 кВ ХТ-1,2 ШинС шинээр суурилуулах ажлыг Вест Энержи ХХК-тай гэрээ байгуулсан. Материал ирэх хугацаа тодорхойгүй он дамжин хийгдэхээр байна.

2023 онд тодотгосон төлөвлөгөөгөөр их засварын 18 нэр төрлийн ажлыг 258.7 сая төгрөгөөр хийж гүйцэтгэхээс 18 нэр төрлийн ажлыг 228.5 сая төгрөгөөр хийж гүйцэтгээд байна.

Ажлын нэр	Төлөвлөгөө		Гүйцэтгэл				
	Тоо	Дүн /сая төгрөг/	2023.12.01-ний гүйцэтгэл		2023 оны 12 сард хийгдэх		ХБГ
			Тоо	Дүн /сая төгрөг/	Тоо	Дүн /сая төгрөг/	
Их засвар	18	258.9	18	228.6		11.0	239.6 93%
ТЗБАХ	19	1,161.0	13	439.9	6	602.6	19 1,042.5 90%
БН д/с-ын өргөтгөл	1	2,402.4	1	840.5		1,561.9	1 2,402.4 100%
Хөрөнгө оруулалт	10	246.1	10	230.6			10 230.6 94%
Нийт	48	4,068.4	41	1,739.6	7	2,175.5	48 3,915.1 96%

Урсгал засвар, ашиглалтын түвшин дээшлүүлэх ажлын төлөвлөгөө гүйцэтгэл

Төлөвлөгөөт урсгал засварын 87 нэр төрлийн ажлыг 14,8 сая төгрөгөөр хийж гүйцэтгэхээс 87 нэр төрлийн ажлыг материалын үнийн өсөлтөөс шалтгаалан 17,2 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн байна.

Төлөвлөгөөт ашиглалтын түвшин дээшлүүлэх болон үзлэг үйлчилгээний ажлаар 121 нэр төрлийн ажлыг 39,6 сая төгрөгөөр гүйцэтгэхээр төлөвлөснөөс 121 ажлыг 32,4 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн байна. Томоохон ажлуудаас дурдвал

- 110/35/6 кВ Өндөрхаан дэд станцад 110 кВ-н Өндөрхаан АШ-ын гүйдлийн трансформатор өндөр хувьтай хэт ачаалагдаж байсныг солих ажлыг зохион байгуулж ажилласан.
- 220/110/35 кВ-н Багануур дэд станцад 35 кВ-н Байдлаг-Б АШ-ын гүйдлийн трансформатор өндөр хувьтай хэт ачаалагдаж байсныг сольж тоноглолын хэвийн найдвартай ажиллагааг тус тус ханган ажиллалаа.

Аянгын улирлын бэлтгэл ажлаар 26 нэр төрлийн ажлыг 2,1 сая төгрөгөөр төлөвлөснөөс 26 ажлыг 2,1 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн.

Ашиглалтын явцад ЦДАШ, цахилгаан тоног төхөөрөмжид гарсан 86 нэр төрлийн гэмтлийг 27.4 сая төгрөгийн зардалтайгаар богино хугацаанд цаг алдалгүй устгаж хэрэглэгчдийг ЦЭХ-ээр тасралтгүй ханган ажилласан байна.

Зардлын нэр төрөл	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Гүйцэтгэлийн хувь
	Тоо	Зардал /мян.төг/	Тоо	Зардал /мян.төг/	
Урсгал засвар	87	14,890	87	17,564	100%
АТД	121	39,664	121	38,272	100%
Аянгын улирал	26	2,160	26	2,736	100%
Гэмтэл устгал			86	27,438	
Нийт дүн	234	56,714	320	86,010	

ЦДАШ-ын баярын өмнөх үзлэг

2023 оны төлөвлөгөөт ээлжит үзлэгийг өөрийн эзэмшлийн 220,110 кВ-н ЦДАШ-уудад 2023 оны 12 дугаар сарын 11-22-ны өдрүүдэд зохион байгуулж хийлээ.




Үзлэг хийсэн бүрэлдэхүүн:

- Засварын мастер А.Энхжаргал, засварын монтер П.Лхагвасүрэн, жолооч Г.Ариунболд, Чойр хэсгийн өндөр хүчдэлийн туршилт хэмжилтийн инженер Ч.Жаргалсайхан засварын монтер Д.Сүхболд, жолооч Д.Гансэлэм Сайншанд дэд станцын ашиглалт шуурхай үйлчилгээний инженер Л.Бямбадорж засварын монтер Б.Сэргэлэн жолооч Х.Энхболд, Өндөрхаан дэд станцын ээлжийн техникч П.Түвшинтөр, засварын монтер Т.Жаргалбаатар жолооч С.Батсуурь нар хийж гүйцэтгэв.

220,110 кВ ЦДАШ-ын анкер болон төмөр бетон тулгууруудын дамжуулагч утас, шлейфны холболт, боолтон холбоос, таталтын хавчаар, скоба, бэхлэх уэль, баригч хавчаар, чичиргээ намжаагч, утас ба троссны таталтын байдал, анкерын шлейфны холболт зэрэгт үзлэг хийсэн. Үзлэгээр нийт 87 гэмтэл илэрсэн ба тасралтад шууд нөлөөлөхөөр гэмтэл байхгүй тул гэмтлийн 2024 оны төлөвлөгөөт урсгал засварын ажлаар хийж гүйцэтгэхээр төлөвлөөд байна.

Мэдээллийг бэлтгэсэн: ЗӨБС-ын
ИА-ны мэдээллийн технологи, компьютерын
инженер Б.Пүрэвсүрэн



ГОВИЙН БҮСИЙН САЛБАР

ХАБЭА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

Салбарын хэмжээнд 2023 оны 11, 12 дугаар сард нарыаар 52, шийдвэрээр 73 ажил хийгдсэн. Наряд, шийдвэрээр ажил гүйцэтгэхэд ажлын аюулгүй байдлыг хариуцагчид болон бригадын бүрэлдэхүүнд онцгой анхааран, шат шатны зааварчилгааг чанартай өгч, аюулгүй ажиллах арга барилд хяналт тавьж ажилласан.

Салбарын хэмжээнд 18 удаагийн дасгал зохион байгуулагдаж 129 ажилтан хамрагдсан, сарын давтан зааварчилгааг 162 хүн, тухайлсан зааварчилгааг 689, ээлжит бус зааварчилгааг 178 ажилтанд өгч ажилласан байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн анхан шатны үзлэгийг 452 удаа хийж 48 зөрчил, II шатны үзлэгийг 24 удаа хийж 69 зөрчил, III шатны үзлэгийг 1 удаа хийж 89 зөрчил илрүүлэн устгаж, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авч ажиллалаа. Галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэгийг 59 удаа хийж ажилласан.

2023 оны IV улирлын ХАБЭА-н III шатны үзлэгийг 2023 оны 11 дүгээр сарын 04-ний өдрөөс 12 дугаар сарын 04-ний өдрийн хооронд дүрэм журмын хэрэгжилт, урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдсэн ажил, ажлын хувцас, хамгаалах хэрэгслийн ашиглалт, техникийн бичиг баримт бүрдүүлэлт, хөтлөлт, өндрийн ажлын аюулгүй ажиллагаа, галын аюулгүй байдал, дотоод хяналт /нарядын системийн мөрдөлт, СЗ-н хуудсын ашиглалт, ША-ны

схем/ зэргийг шалгаж, дэд станцын анхдагч хэлхээний тоноглолуудад үзлэг хийж, үүрэг даалгавар өгөн, ажилтнуудын санал хүсэлтийг авч, зөвлөгөө өгч ажилласан.

Өмнө II улирлын үзлэгээр илэрсэн зөрчлийг арилгасан байдал, өгсөн үүрэг даалгаварын биелэлт 87.5%-тай байна гэж комисс дүгнэсэн.

215, 216 дугаар агаарын шугамын тулгуур №15-16, 16-17-н хооронд трассын доор Дундговь аймгийн Сайнцагаан сумын ард иргэд хог асгасан байсныг Сайнцагаан сумын засаг даргад албан тоотойр хүсэлт өгсөний дагуу 11 сарын 01-02-ны өдрийн хооронд 150 машин хогийг цэвэрлэж агаарын шугамын трассыг чөлөөлсөн.



Хог асгасан тулгуур

Хогийг зайлуулсан дараа


215, 216 дугаар агаарын шугамын тулгуур №163-164 хооронд Дундговь аймгийн Луус сумын малчин айл бэлчээр хашиж хашаа татсан байсан зөрчлийг арилгуулахаар Луус сумын засаг даргад албан тоотойр хүргүүлсэн. Үүний дагуу 11 сарын 19-ний өдөр малчин айлын татсан хашааг агаарын шугамын хамгаалалтын зурвасаас гаргаж татуулан зөрчлийг арилгасан.



Хашаа татсан тулгуур

Хашааг холдуулж татсаны дараа

Байгаль цаг уурын өөрчлөлт, хүн амын нягтаршилтай холбоотой гамшиг аль ч цаг үед үүсч болох эрсдэлтэй өнөө үед ажилтан нэг бүр гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангаж хувийн аранзгыг бүрдүүлэх зорилгоор 11 сарын 01-ний өдрөөс 11 сарын 30-ны өдрийн хооронд салбарын оффисын 57 ажилтан, 5 дэд станцын 45 ажилтан 18 нэр төрлийн хэрэгсэл бүхий хувийн аранзгыг бүрдүүлж ажлын байранд байршуулсан.



Аранз бүрдүүлсэн ажилтнууд

Их болон урсгал засвараар хийгдсэн ажлууд:

225-р агаарын шугамын их засварын ажил хийгдлээ.

Засварын мастер Б.Лхагвасүрэнгээр ахлуулсан 9 хүний бүрэлдэхүүнтэй бригад 2023 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр, суудлын 1 автомашин тусгай зориулалтын 3 автомашинтай 225-р агаарын шугамын их засварын ажлаар ТН594 цууралт үүссэн СК-26 бетон тулгуурыг солих ажил гүйцэтгэв.



Цуурсан тулгуур солих ажлын явц

Мак ХХК-тай байгуулсан гэрээний дагуу 220/22/35 кВ-н Цагаансуварга дэд станцын урсгал засварын ажил гүйцэтгэв.


Мак ХХК-тай байгуулсан гэрээний дагуу 220/22/35 кВ-н Цагаансуварга дэд станцын урсгал засварын ажлыг 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдрөөс 12-ны өдрүүдэд засварын албаны 8 хүний бүрэлдэхүүнтэй бригад хийж гүйцэтгэсэн.

АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

ЦДҮС ТӨХК-ийн 2023 оны 11 дүгээр сарын 24-ны өдрийн 02/1646 тоот албан бичгийн дагуу хийх үзлэгийг сар бүрийн 1, 17-ны өдрүүдэд тусгай маягтын дагуу хийж ажиллаж байна. 2023-2024 оны өвлийн их ачааллын хяналт хэмжилтийг 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 04:00, 12:00, 19:00, 23:00 цагуудад салбарын харьяа дэд станцуудын хүрээнд амжилттай зохион байгуулсан.

35 кВ Оюу А:Б АШ-н ТН20-19 хооронд 2-р фазын дамжуулагч тасарч унасан гэмтэл устгах ажил гүйцэтгэв.

Шугамын засварын мастер Б.Лхагвасүрэнгээр ахлуулсан 7 хүний бүрэлдэхүүнтэй бригад, 2 машин механизмтай 2023 оны 11 дүгээр сарын 13-16-ны өдрүүдэд гэмтэл устгах чиглэлээр дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд 35 кВ Оюу А агаарын шугамын тулгуур №19-20 хооронд 2-р фазын дамжуулагчид 30м оруулга хийж анкер тулгуурт татаж бэхэлсэн. 35 кВ Оюу А:Б агаарын шугамын тулгуур №20-10 хооронд 3-н фазын дамжуулагч утсыг ролик дээр тавьж суллах ажил гүйцэтгэсэн.



Оруулга хийж утас суллах ажлын явц

МАК ХХК-тай байгуулсан гэрээний дагуу 221:222-р агаарын шугамын урсгал засварын ажлаар хулгайд алдагдсан 42 ширхэг деталиудыг нөхөж хийх, элемент хагарсан гэмтэл устгах ажил хийгдсэн. Уг ажлыг шугамын засварын мастер Б.Лхагвасүрэнгээр ахлуулсан 7 хүний бүрэлдэхүүнтэй бригад, 2 машин механизмтай 2023 оны 11 дүгээр сарын 07-09-ны өдөр нийт 10 тулгуурт 42 ширхэг деталь нөхөж хийх, 4 тулгуурт хагарсан аэродинамик элемент солих, 4 тулгуурт хагарсан элемент солих, 221:222-р агаарын шугамын 49 цэгт аюулгүй ажиллагааны плакат нөхөж хийж гүйцэтгэсэн.



Алдагдсан деталь нөхөж, хагарсан элемент солих ажлын явц

110/35/10 кВ Даланзадгад дэд станцад 35 кВ Далан А:Б агаарын шугамын гүйдлийн трансформатор буудсан гэмтлийг устгах ажил гүйцэтгэсэн.

110/35/10 кВ Даланзадгад дэд станцад 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрүүдэд 35 кВ Далан А:Б агаарын шугамын гүйдлийн трансформатор буудсан гэмтлийг засварын албаны дарга О.Хоринтаванаар ахлуулсан 11 хүний бүрэлдэхүүнтэй бригад 2 машин

механизмтай хийж гүйцэтгэсэн. Уг ажилд 110/35/10 кВ Мандалговь дэд станцын 35 кВ Гурвансайхан агаарын шугамын гүйдлийн трансформатор бүхий вакум таслуурыг шилжүүлэн 35 кВ Далан Б агаарын шугамын вакум таслуураар сольж тавих болон 35 кВ Далан А агаарын шугамын А, С фазын гэмтсэн гүйдлийн трансформаторыг солих ажил хийж гэмтлийг бүрэн засварлаж хүчдэлд залгасан.



Гүйдлийн трансформатор солих ажлын явц

Чангарсан холболт суллах ажлын явц

220/110/35 кВ Оюутолгой дэд станцад хүйтрэлтэй холбоотойгоор чангарсан холболтын утсыг суллах ажил гүйцэтгэв.

Шугамын засварын мастер Б.Лхагвасүрэнгээр ахлуулсан 5 хүний бүрэлдэхүүнтэй бригад 2023 оны 12 дугаар сарын 16-ны өдөр 220/110/35 кВ Оюутолгой дэд станцын 220 кВ ЦШ-н А,В фазын холболтын утас, 110 кВ-н ЦШ-н А,В,С фазын холболтын утас, 35 кВ-н В фазын холболтын утасны чангаралтыг суллах ажил гүйцэтгэсэн. Мөн 110 кВ ХТ-2-н ШинС-н тулгуур изолятор дээрх чангарсан

холболтын утсыг суллах ажил гүйцэтгэв. 220 кВ Хятад А агаарын шугамын гүйдлийн трансформаторын тосны түвшин заагч цонхны шил хагарсан гэмтлийг засварлах ажил хийж гүйцэтгэсэн.

225-р агаарын шугамын овор бариулах ажил гүйцэтгэв.

Шугамын засварын монтер Б.Алтангэрэлээр ахлуулсан 3 хүний бүрэлдэхүүнтэй бригад 2 машин механизмтай 11 дүгээр сарын 04-10-ны хооронд 225-р агаарын шугамын тулгуурын нийт 16 цэгт хөрсний тэгшилгээ хийж овор бариулах ажил гүйцэтгэсэн.




Хөрсний тэгшилгээ хийж буй явц

Трансформаторын тос нэмэх ажлын явц

Клин инержи ази ХХК-тай байгуулсан гэрээний дагуу 110/35 кВ Цэций СЦС-н ээлжит үзлэг шалгалтыг 11,12 дугаар саруудад хийж гүйцэтгэсэн. 110/35 кВ Цэций СЦС-н 35 кВ НУО-1 ТР-н тосны түвшин дундарсан тул 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр яаралтай дуудлагаар засварын албаны дарга О.Хоринтаван, засварын монтер Н.Гомбодорж нар 35 кВ-н НУО-1 ТР-т тос нэмэх ажил хийгдсэн.

Мэдээллийг бэлтгэсэн: ГБС-ын ЗААА-ны дарга Ц.Ганнэгт




ЦДҮС ТӨХК-ИЙН 2023 ОНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН шилдэг 10 ажил

1. “Сонгино” батерей хуримтлуурын станцыг Эрчим хүчний нэгдсэн системд залгаж зүгшрүүлэлт хийсэн. Монгол улсын анхны “220/22/35 кВ-ын 80 МВт-ын том чадлын “Батерей хуримтлуурын станцыг ашиглалтад оруулах ажлын хүрээнд 220/110/35 кВ-ын Сонгино дэд станцад 110 кВ-ын шинээр суурилуулсан бүх тоноглол, “Сонгино БХС”-ын үндсэн 2, дотоод хэрэгцээний 4, инверторын 32 трансформатор, 110/35/0.69/0.4 кВ-н бүх тоноглолыг хүчдэлд залгаж, ачаалал авахуулах нийт 2042 үйлдэл бүхий сэлгэн залгалтын программыг боловсруулж, сэлгэн залгалтын үйлдлийг гардан гүйцэтгэж, амжилттай ажиллагаанд залгалаа. Уг батерей хуримтлуурыг ажиллагаанд залгаснаар өвлийн оргил ачааллын цагуудад оргил ачааллыг хааж оролцох шилжүүлэх, импортын эрчим хүчний хэмжээ буурах боломжтой болсон.



“220/22/35 кВ-ын 80 МВт-ын том чадлын
“Батерей хуримтлуурын станц

2. Хяналт, удирдлагын мэдээллийн SCADA системд Улаабаатар салбарын шилэн кабельд холбогдсон 28 дэд станцыг хамарсан сүлжээ үүсгэсэн. POWER SCADA системд Төвийн бүсийн салбарын 110/6 кВ-ын Давхар, Бурхант, Үйлдвэр дэд станцуудын РХА-ийн төлөв байдлыг оруулан алсаас удирдах боломжтой боллоо.



УБС-ын 28 дэд станцад сүлжээ үүсгэсэн байдал




ТБС-ын Алсын удирдлагаар таслах залгах үйлдлийг хянах дэлгэц

3. Багануур дэд станцын 220 кВ-ын ИХБ-ийн өргөтгөл, РХА-ийн шинэчлэлт, 220 кВ-ын Бөөрөлжүүтийн цахилгаан станцын 220 кВ-ын ЦДАШ-ын барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэв.





220/110/35 кВ-ын Багануур дэд станцын өргөтгөл

4. “Инженер Монгол Улсын Оюутолгой төсөлд зориулж Өвөр- Монголын Эрчим хүчний Олон Улсын Хамтын ажиллагааны компанитай “Цахилгаан эрчим хүч худалдан авах, худалдах тухай гэрээ”-ний хүчин төгөлдөр үйлчлэх хугацааг сунгаж, “Нэмэлт гэрээ”-г 2023.05.12-ны өдөр байгуулсан нь хамтын ажиллагааг эрчимжүүлэх, компанийн эдийн засагт томоохон хувь нэмэр оруулж байгаа онцгой чухал алхам боллоо.




Гэрээ байгуулах үйл явц


5. 110 кВ-ын Ерөө-Бугант ЦДАШ-ын тасралтын судалгаа, тооцоонд үндэслэн ОХУ-ын “Полимер аппарат” компанийн үйлдвэрлэсэн хэт хүчдэл хязгаарлагчийг нийт 35 тулгуурт суурилуулсан. Хэт хүчдэл хязгаарлагчийг суурилуулсанаар аяндын улиралд агаарын шугамын тасралт багасах боломжтой.



ЦДАШ-д цэнэг шавхагч суурилуулсан байдал



6. Байгалийн гамшигт үзэгдэл, огцом хүйтрэлт, хүчтэй салхи, аадар борооны нөлөөллөөс 220 кВ-ын 203, 204 дүгээр ЦДАШ-ын тулгуур № 68, 220 кВ-ын 215, 216-р шугамын тулгуур №32, 110 кВ-ын Хархорин-А,Б ЦДАШ-ын №463-аас 486-р тулгуурууд мөн №679-өөс 683-р тулгуурууд хугарсан аваарыг богино хугацаанд арилгаж, хурдан шуурхай гэмтлийг засварлаж найдвартай ажиллагааг хангасан.



220 кВ-ын 203, 204-р шугамын тулгуур №68-д гэмтэл устгаж, сэргээн босголт хийж байна.



220 кВ-ын 215, 216-р шугамын тулгуур №32-д гэмтэл устгаж, сэргээн босголт хийж байна.



110 кВ-ын Хархорин-А, Б АШ-д гэмтэл устгаж, сэргээн босголт хийж байна.

7. 220/110/35 кВ-ын Чойр дэд станцаас буусан Автотрансформаторт бүрэн задаргаат их засварын ажил, 110/10 кВ-ын Буянт-Ухаа дэд станцын Т-2 трансформаторын гэмтлийг засварласан. Эрдэнэт дэд станцад 63 МВА-ийн Т-1, Т-2 трансформатор, Баянхонгор дэд станцад 16 МВА-ийн Т-1 трансформатор, Мөрөн дэд станцад 6,3 МВА-ийн Т-3 трансформатор, Хархорин дэд станцад 15 МВА-ын Баянхонгор дэд станцад 5 МВА-ын СВГ суурилуулсан.



Суурилуулсан трансформатор




Хархорин дэд станцын СВГ төхөөрөмж



Трансформаторын засварын ажлын явц

8. Ажилтны үндсэн цалинг тодорхой хувь хэмжээгээр үе шаттай нэмэгдүүлсэн.



9. “Инженер техникийн ажилтнуудын зөвлөгөөн -2023”-ыг зохион байгуулав. 220 кВ-ын Мандалговь-Арвайхээр, Багануур-Чойр цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, 110/10 кВ-ын Парк дэд станцын техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах ажлыг гүйцэтгэв.



“Инженер техникийн ажилтнуудын зөвлөгөөн -2023”-д оролцсон инженер техникийн ажилтнууд




Гүйцэтгэсэн Техник эдийн засгийн үзүүлэлт


10. TORKLE – 930 маркийн багажаар 50 дэд станцын аккумуляторын байгууламжид хэмжилт хийж шаардлага хангахгүй болсон шулуутгагч болон аккумуляторын батареиг тодорхойлсон. OMICRON CPC-100 маркийн багажаар 220, 110 кВ –ын ЦДАШ-ын бодит эсэргүүцлийг хэмжиж микропроцессорын реле хамгаалалт болон аваарын бичигч төхөөрөмжид шугамын параметрийн бодит утгыг оруулсан.



Батерейнд хэмжилт туршилт хийж байна



OMICRON CPC-100 маркийн ЦДАШ-ын бодит эсэргүүцлийг хэмжих багажаар хэмжилт хийж байна



“НЭГЭН ЖАРНЫ ТҮҮХ”

БУЛАН

ТАЙЛБАР: Монгол Улсад цахилгаан дамжуулах сүлжээ үүсэж хөгжсөний нэгэн жарны түүхэн ой 4 жилийн дараа тохиох болно. Түүхийн үйл явцтай холбогдуулан Дамжуулах сүлжээ сонинд “НЭГЭН ЖАРНЫ ТҮҮХ” буланг Ахмадын хорооноос шинээр нээж техникийн дэвшил, түүнийг эзэмшигч хөдөлмөрийн хүмүүсийн тухай цувралаар нийтэлж байна. Бид өмнөх дугаартаа Хангайн бүсийн салбарын түүхэн замналыг нийтэлсэн бол энэ дугаартаа Зүүн-Өмнөд бүсийн салбарын он дарааллын товчооныг хүргэж байна.

ЗҮҮН-ӨМНӨД БҮСИЙН САЛБАРЫН ОН ДАРААЛЛЫН ТОВЧООН (ЦУВРАЛ-4)

Үргэлжлэл

2015 ОН: Багануур дүүргийн шилдэг аж ахуйн нэгжээр шалгарсан.

2015 ОН: Эрчим хүчний үйлдвэр компаниудын шуурхай ажиллагааны ажилтнуудын дунд зохион байгуулсан ажил мэргэжлийн тэмцээнд Б.Ганбаатар ахлагчтай “Зөв” баг 2-р байр эзлэв.

2015.09.05-11.10:Хэнтий аймгийн цахилгаан хангамжийн найдвартай болгох зорилгоор Засварын албаны дарга Б.Түвшинбаярын удирдлага дор салбарын ажилтнууд 110/35/6 кВ Өндөрхаан дэд станцын суурилагдсан хүчин чадлыг нэмэгдүүлэх, 10 кВ ячийк бүхий ХХБ бүхий өргөтгөлийн ажлыг хийж гүйцэтгэв.

2016.10-р сарын 23: Салбарын даргаар Н.Мөнгөнхөлөгт томилогдон ажилласан.

2018 ОН: Монгол улсын Засгийн газраас баталсан төсөл хөтөлбөрийн хүрээнд 220/110/35/6 кВ Чойр дэд станцын 220/110 кВ ИХБ-ийг тус бүр 18 ячийктай байхаар зураг төсөл хийгдэж, өргөтгөлийн ажлыг “Алтай трест” ХХК концессийн гэрээгээр хийж дуусган хүчдэлд залгасан ба суурилагдсан хүчин чадлын хэмжээ 400 мВА болж, реле хамгаалалт автоматикийг бүрэн шинэчилж нэгдсэн сүлжээний СКАДА системд холбосон.

2018 ОН: Дорноговь аймгийн нутаг дэвсгэрт баригдсан “Салхин станц”-ыг Төвийн Эрчим Хүчний Системтэй холбох, мөн аймгийн Алтанширээ сумын нутагт байгаа нефтийн орд газрыг түшиглэж баригдах “Газрын тос боловсруулах үйлдвэр”-ийн цахилгаан эрчим хүчний хангамжийг шийдэхээр 110/35/10 кВ Сайншанд дэд станцын 110 кВ ИХБ-ийг 12 ячийктай байхаар зураг төсөл хийгдэж, Засварын албаны дарга Б.Түвшинбаярын удирдлага дор салбарын ажилтнууд өргөтгөлийн ажлыг 2018 оны 04 дугаар сарын 20-ноос 07 дугаар сарын 21-ний хооронд хийж гүйцэтгэн хүчдэлд залгасан.

2018 ОН: Дорноговь аймгийн Замын-Үүд сумын нутаг дэвсгэрт баригдсан “Нарны гэгээ” дэд станцыг ТЭХС-тэй холбохоор 110/10 кВ Замын-Үүд дэд станцын 110 кВ ИХБ-нд өргөтгөлийн ажлыг “Смарт Крафт” ХХК 2018 оны 02 дугаар сарын 01-нээс 06 дугаар сарын 20-ны хооронд хийж гүйцэтгэсэн.

2018 ОН: Дорноговь аймгийн Замын-Үүд суман дах “Бүс нутгийн Ложистик төв” болон хилийн боомтыг ЦЭХ-р ханган зорилгоор 110/10 кВ Борхойн дэд станцыг ашиглалтанд оруулж 2018 оны 08 сарын 21-нд хүчдэлд залгасан. Уг дэд станц нь 32 МВА-ийн суурилагдсан хүчин чадалтай.

2019.02 сар: Салбарын ерөнхий инженерээр Б.Түвшинбаяр томилогдон ажилласан.

2019.05.21: Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байрлах нефтийн орд газрыг түшиглэн баригдаж буй “Газрын тос боловсруулах үйлдвэр”-ийг цахилгаан эрчим хүчээр хангахаар 110/10 кВ-н Ширээт дэд станц нь 2019 оны 05 сарын 21-нд хүчдэлд залгаж, ашиглалтанд оруулсан. Суурилагдсан хүчин чадал нь 6.3 МВт

2021.08.09: Салбарын даргаар П.Ганбаяр томилогдон ажилласан.

2022 ОН: Чадамжийн гэрчилгээний сургалтад хамрагдаж байгаа ажилтнуудад Монгол Улсын хэмжээнд хүчинтэй төдийгүй олон улсад /Австрали, Орос, Хятад, Япон, Солонгос, Чех, Азийн бусад зарим орнуудад/ хүчин төгөлдөр гэрчилгээг олгож эхэлсэн.

2023 ОН: 220 кВ Багануур-Бөөрөлжүүтийн ЦДАШ-ын багц хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 18 км ЦДАШ, 220/110/35 кВ Багануур дэд станцын 220 кВ ил хуваарилах байгууламжийн өргөтгөлийн ажлыг өөрсдийн ажилтнуудынхаа хүчээр хийж гүйцэтгэн хүчдэлд залгасан.

ГОВИЙН БҮСИЙН САЛБАРЫН ОН ДАРААЛЛЫН ТОВЧООН (ЦУВРАЛ-5)

2013 он: Монгол орны өмнөд хэсэгт стратегийн томоохон орд газруудын олборлолтын ажлууд эрчимтэй явагдаж эрчим хүчний хэрэглээ өсөн нэмэгдэж уул уурхайн бүс нутгийг цахилгаан эрчим хүчээр тасралтгүй найдвартай хангах зорилгоор ЦДҮС ТӨХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2013 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн хурлын 13 дугаар тогтоолоор шийдвэр гарч компанийн гүйцэтгэх захирлын 2013 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн Б/88 дугаар тушаалаар Говийн бүсийн салбар байгуулагдсан.

Тус салбарыг анх байгуулагдахад салбарын анхны даргаар Д.Цэрэндамба томилогдон 2013 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн компанийн өргөтгөсөн шуурхай хуралдаан дээр Гүйцэтгэх захирал Ж.Равдандоржоос салбарын тамга, гэрчилгээг гардан авсан. Салбарын төв нь Өмнөговь аймгийн Цогтцэций суманд байрлан Тавантолгой дэд станцын ажилтнуудын амьдрах зориулалттай 4 ширхэг зөөврийн сууцтай үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Салбарын анхны ерөнхий инженерээр М.Энхсод, ХАБЭАИ-ээр Б.Батхуяг, ахлах нягтлан бодогчоор Н.Мөнх-Эрдэнэ нар томилогдон ажиллаж байсан.

Тус салбар нь 110/35/10 кВ-ын 4 дэд станц, 62 МВА суурилагдсан хүчин чадал бүхий 5 иж бүрдэл хүчний трансформатор, 220кВ-ын овортойгоор Мандалговь-Тавантолгой, Тавантолгой-Оюутолгой 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугам нь нийт 381,3 км ба нэг хэлхээнд шилжүүлснээр 762,6 км урт цахилгаан дамжуулах агаарын шугам, 110кВ-ын овортой Тавантолгой-Даланзадгад нэг хэлхээт 86,9 км цахилгаан дамжуулах агаарын шугамын болон бусад тоноглолуудын тасралтгүй найдвартай ажиллагааг ханган ажиллаж эхэлсэн.

110/35/10кВ Тавантолгой дэд станц нь:

110/35/10 кВ-н Тавантолгой дэд станц нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дэвсгэрт 2012 оноос эхлэн баригдаж, 2013 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр 110 кВ-н Мандалговь АШ-аар анхны хүчдэл авч ашиглалтад орсон.

Улаанбаатар-Мандалговь-Тавантолгой-Оюутолгой 220кВ-ын 2 хэлхээт ЦДАШ, дэд станцуудын зураг төсөл, Мандалговь-Тавантолгой-Оюутолгойн 220кВ-ын 2 хэлхээт ЦДАШ, 110кВ-ын дэд станцын барилга угсралт, барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комисс Тавантолгой-Оюутолгой 220кВ-ын 2 хэлхээт ЦДАШ

220/110/35кВ-ын Оюутолгой дэд станцыг 2013 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр улсын комиссоос хүлээн авсан. Тус дэд станцын ахлах инженерээр З.Бат-Эрдэнэ томилогдон ажиллаж байсан.

220/110/35кВ Оюутолгой дэд станц нь:

Тус дэд станц нь 110кВ-ын 1 систем шинтэй, дотоод хэрэгцээндээ БНХАУ-д үйлвэрлэгдсэн 630 кВА чадалтай өндөр талдаа 1,25 хувийн шатлал бүхий ачаалал дор хүчдэл тохируулагчтай 1ш хүчний трансформатор, шугамын хүчдэлийг болон синхрон залгалтыг хангах зорилгоор шугамын 1 фазад VPU маягийн хүчдэлийн трансформатор, ЗАР1F хийн таслуурууд, AGU-40.5 тосон хөндийрүүлэгтэй гүйдлийн трансформатор, GW4A нэг болон 3 фазын хуурай салгуурууд, Y10W1-96 маягийн хэт хүчдэл хязгаарлагч суурилуулсан.

110/35/10кВ Даланзадгад дэд станц:

110/35/10 кВ-н Даланзадгад дэд станцыг 2013 оны 08 дугаар сарын 27-ны өдөр “ДСЦТС” ХК болон техникийн комиссын бүрэлдэхүүн хамтран туршилтын хүчдлийг залгасан ба 2013 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр албан ёсоор ЦДҮС ТӨХК Говийн бүсийн салбарт харьяалагдах болсон. 110/35/10 кВ-н Даланзадгад дэд станц нь БНХАУ-д үйлдвэрлэгдсэн 10000 кВА-н 2 хүчний трансформатортай ба нийт суурилагдсан хүчин чадал 20 МВА. Дэд станцын бусад тоноглолууд болох хэмжүүрийн трансформаторууд, дотоод хэрэгцээний трансформатор, хийн болон вакум таслуурууд, хуурай салгуурууд нь БНХАУ-д үйлдвэрлэгдсэн.

Трансформатор өвлийн их ачаалалд 70-100%, зуны бага ачаалалд 30-70% хүртэл ачааллагдаж байна. Дэд станц нь 35 кВ-н Хүрмэн, Жуулчин, Далан-А, Б 3 гаргалгаа, 10 кВ-н Эрчим-1, Эрчим-2, Ханхонгор, Эмнэлэг, Полигон гэсэн 5 гаргалгаатай. Өмнөговь аймгийн төв болон 4 сумын 100 гаруй төсвийн байгууллага, 1555 орчим ААН байгууллага, 10878 гаруй айл өрхийг ЦЭХ-ээр тасралтгүй найдвартай ханган ажиллаж байна. 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдөр ДэдЦС-ын Т-4, Т-5 транформаторуудаар зэрэгцээ ажиллагаанд залгасан. ДэдЦС нь зэрэгцээ ажиллагаанд холбогдсоноор нэгдсэн сүлжээнд 3,4 МВт хүртэл ЦЭХ нийлүүлж байна.

110/35/10 кВ Мандалговь дэд станц:

110/35/10 кВ Мандалговь дэд станц нь 110 кВ-н Тавантолгой 1 гаргалгаа, 35 кВ-н Төв, Олгойнговь, Луус, Гурвансайхан гэсэн 4 гаргалгаагаар 110/35/10/0,4 кВ-н дэд станцуудыг найдвартай цахилгаан эрчим хүчээр тасралт сааталгүй хангаж ажиллаж байна. Тус дэд станц нь 110 кВ-ын 1 систем шинтэй, дотоод хэрэгцээндээ ЗХУ-д үйлвэрлэгдсэн 63 кВА чадалтай 1, БНХАУ-д үйлдвэрлэсэн 160 кВА чадалтай 1 трансформатортай, өндөр талдаа 1,32 хувийн шатлал бүхий ачаалал дор хүчдэл тохируулагчтай 10000 кВА-н 1ш хүчний трансформатор, шугамын хүчдэлийг болон синхрон залгалтыг хангах зорилгоор шугамын 1 фазад VPU-120 маягийн хүчдэлийн трансформатор, ЛТБ145Д1/В хийн таслуурууд, AGU-40.5 тосон хөндийрүүлэгтэй гүйдэлийн трансформатор, СSBII-2АМ нэг болон 3 фазын хуурай салгуурууд, ВКГКЛ-1100/10,5 маягийн хэт хүчдэл хязгаарлагч суурилуулсан.

2014 он:

Компанийн ТУЗ-өөс гаргасан шийдвэрийн дагуу салбарын төв нь 2014 оны 07 дугаар сарын 25-ны өдрөөс Дундговь аймгийн Сайнцагаан суманд шилжин ирсэн. Тухайн үед салбарын дарга Д.Цэрэндамба, ерөнхий инженер Г.Соронзонболд, ХАБЭАИ Ц.Готовдулам, ЗААА-ны даргаар Б.Батхуяг, СЭЗА-ны дарга бөгөөд ахлах нягтлан бодогч Б.Жавхлан нар ажиллаж байсан.

Эрчим хүчний яамнаас Өмнөговь аймгийн Ханбогд, Баян-Овоо сумдын 1403 хэрэглэгчдийг эрчим хүчний нэгдсэн системээс хангах зорилгоор хэрэгжүүлсэн ажлын хүрээнд Оюутолгой дэд станцад схемийн өөрчлөлт хийж, шугам залгах ажлыг Говийн бүсийн салбар 2015 оны 6 дугаар сарын 25-нд хийж гүйцэтгэсэн.

Тус салбарын 2014 оны Тэргүүний ажилтнаар Тавантолгой дэд станцын ахлах инженер Б.Мянганбуу, суудлын автомашины жолооч Б.Батбаатар, ээлжийн монтёр С.Нэмэхбаяр нар тус тус шалгарсан.

[Үргэлжлэлийг дараагийн дугаарт](#)

Эрхлэн гаргасан: Захиргаа удирдлагын хэлтсийн хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах мэргэжилтэн Д.Энхбаяр